

Гүйцэтгэх хугацаа-100 минут
НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Нийт оноо 50
[20 оноо]

1.1 Санамж:

Эхийг анхааралтай уншиж ойлгоод асуултад хариулаарай.

Хариултын олон хувилбараас зөвхөн нэгийг сонгож, хариултын хуудсан дээр зааврын дагуу будаарай.

Зөв хариулт бүр 2 оноотой.

ГУРВАН ХЭМЖЭЭС

Дорнын тооллоор зул сар барагдах шөнө Загар хачин их гэрэл туяатай зүүдлэв. Тэнгэр нь гүн цэнхэр, моносны цагаан цэцэгс малгайлсан цас бударсан мэт цагаан, үнэр бал бурам шиг анхилам. Ганганд шургасан харанхуй ширэнгийн хөвд мөчрийг санагдуулам үзэсгэлэнт хавцлын ирмэгт Загар шав шар дээлтэй сүүж байх аж. Хачирхалтай нь өмссөн тэр гоёмсог шар дээл бол түүний тэрслэгч анд Сугарынх байх юм гэнэ. Хажуугийн бүлгийн эх довцог дээр саяхан идшинд нядалсан хоёр жилийн сувай хар халзан үнээ нь сарлагийн боодой шиг цасан цагаан тугал хөхүүлэн зогсож байв. Хүрц тод зүүднээс салж чадахгүй гайхах баясах зэрэгцэн, Загар сэрж гар чийдэн тэмтрэн ханын том цаг руу тусгавал дөрвөн цаг дөчин хормыг зааж байв. Энэ цагт үнэгэн харахуйд сэрдэг болоод үджээ. Тэгээд ёс юм шиг жимсний шилэнд давсгаа суллаад орчлонг эргэцүүлэн хэвтдэг заншил тогтжээ. Яг үүр цайхын алдад эргээд нойр хүрэх авч морь малын ажил монгол хүнийг ямар үнтүүлж хэвтүүлэх биш. Сайхан зүүд хэмээн бэлгэшээх сацуу, “Энэ муу Сугар зүүдэнд орохоос ч бас хоцрохгүй шүү” гэж үндүүцэв.

Загар нэг удаа малын эрлээр Сугарынд хонохдоо нохой унталтаар унтаж, эхнэртэйгээ яах нь вэ? гэж саваагүйтэн чагнаж байгаад нам унтаж, харин Сугар өглөө эртлэн босоод алдуул хэдэн адууг нь хөөгөөд ирсэн байж билээ. Сугарт хордсондоо “Надад олдохгүй байсан мал Сугарт олддог нь ч юув” гэж адгуус малд үүр нь хүрч байжээ. Энэ мэтийг нэхэн санахдаа “Үргэлж нэг алхмын үрд яваад байж шүү” гэсэн бодол гялсхийн орж ирэв. Тэр бодол даамжирч, Сугараас болж хорссон анхны хайрын зурвас зөрөг руу хөтлөн аваачив.

Жүрхин овгийн Зүсэм гэгч алаг нүдэн охин амьсгал зүрхнээс салахаа байж алтан бумба мэт ариунаар мөрөөдсөн гэрэлт үедээ зүрхэндээ гүн шарх авсан юм. Нэгэн насны шарх авсан тэр өглөө Зүсэмийн гадаа Сугарын морь уяатай хоносон байж, Загарын үйлийн лайтай хоёр нүд түүнийг өөрөө олж үзсэн юм. Сугар, Зүсэм дээр хоноод үүрээр мордохыг, хацар нэвт туяарсан Зүсэм хайрын нүдээр энхрийлэн үдэхийг Загар цээжээ хорсгон харсаар хоцорч билээ.

Цас ороод хоножээ. Эхнэр нь өрх татах үед хэсэг цас шархийн зүүхан дээр унав. Загар “Энэ амьтныг би шөнө бүхэн тэвэрч, шүр болтол ханилж дээ. Эмс эхнэрүүд анхныхаа эрийг мартдаггүй юм гэсэн. Боддог л байлгүй” гэж эхнэрийнхээ тухай олиггүй юм бодно. Загарын дотор хорсон, Зүсэм бүсгүйн аньсага буулган хар цагаан дүүгүй ширтдэг алаг нүдийг санахаараа ингэж шалтгаангүйгээр эхнэртээ хорсдог байлаа. Өөрийгөө бодсон ч, эхнэрээ харсан ч Сугарт дургуй нь хүрч, “Сугар анхнаасаа л миний өмнө явж ирж” гэсэн дүгнэлт өөрийн эрхгүй орж ирсээр.

Сугарыг мэргэн түргэн гэлцдэг байлаа. Загарын аазгай нь хөдөлж өөрийн эрхгүй ярвайна.

Сэтгэлийн мұхрын чулуу мэт хатуу хорслоо тайлж болох мэргэн арга бодож олжээ. Загарын үгнээс зөрдөггүй, сэмхэн Сугараар мал хуйгаа мэргэлүүлдэг дорой ноомой залуу бий. Түүнд урьдаас бэлдэж хадгалсан хоёр чулууг өгч,

-За чи Сугар дээр очоод энэ хоёр чулууг үзүүл. Та энэ хоёр чулууг үзээд аль нутаг нь надад өлзий буянаа өгөх вэ, хэлж өгөөч ? гэж гүй. Тохиролцох нэг юм байна. Би одоо мордоод тэднийд сүүж байя. Чи миний араас удалгүй очиж миний дэргэд асууна шүү.

-Ямар учиртай чулуу юм бэ?

-Хариулт нь надад сонин байна.

Тэр хоёр чулууны нууц гэвэл нэг нь Дүнд булагийн эхээр давдаг давааны оройн овооны чулуу. Нөгөө нь гэвэл Дэрсгийн худаг ухахад ёроолоос нь гарсан чулуу байжээ. Залуу үүнийг сонсоод бас л догдлон дотор нь загатнажээ. Загар “Үүнийг тааж мэднэ гэж юу байхав, барьц алдан тагжирч сүүхад чинь бахаа ханатал даапаалах юм шүү” гэж бодож байлаа.

Хар бага насны анд Сугар, Загар хоёр тамхилангаа нутаг усны сонин сайхныг хуучилж суутал, Загарын захиастай залуу орж ирэв. Мэнд үс мэдэлцээд, даалингаа ухан хоёр чулуу гаргаж, чин сүжиг илэрсэн нүүрний хувиралгүй харцаар Сугарын өөдөөс чулууг барьж асуув. Загар ханцуйдаа инээж байв. Сугар сэрдхийн, Загарыг нэг, чулууг нэг харлаа. Нэг нэгээр нь эргүүлж тойруулан сонжиж дуусаад бах нь ханасан янзтай инээвхийлэн хамрын тамхиа овоолоход Загарын бие зарс гээд явчихав. Сугар торох ч үгүй,

-За залуу минь тогтвол энэ нь зүгээр юм гэж овооны чулууг имрээд өгөв. Харин багтвал энэ нь ч зүгээр юм гэж худгийн чулууг буцааж барив. Загар балмагдахдаа хамаг шар үс нь бослоо.. Ам руугаа алгадуулсан залуу год үсрэн гарч одов. Өөрийг нь хүндлэн бишрэх сэтгэл төрж эхэлсэн Загарт, Сугар аминчхан яриа дэлгэж

-Зүүн баруунгүй хатгуулж өвдөхөөр, хааяа би хоёр зүрхтэй юм биш байгаа гэж дэмий юм бодох юм. Ямар балдуушийн хоёр зүрх байхав дээ. Титэм судасны нарийсал гэнэ дээ хө. Ханат гэр нь холдож хадан гэр нь ойртож байгаа юм даг үү даа гэв.

Эрүүл саруул Сугарыг өвчин ярьсанд урамшив үү. Ямар ч байсан Сугар өөрөөс нь нэг алхмын өмнө явж ирсэн. Бас өөрөөс нь нэг алхмын өмнө үхэж магадгүй юм байна гэж бодсон үү. Хоёр чулуунд гартуулж чадаагүй ч, үл мэдэгдэх ялалт байгуулсан шиг санагдаад явчихжээ. Эсвэл хүлгийн нүрүүнд гарвал санаа нь амардаг морьтны халуун цустайн шинж юм үү. Ямар ч байсан Загарын сэтгэлийн мұхар дахь хар хорын бодол салхинд хийсэх мэт цэлмэж, магнай тэнийтэл бах нь ханаад шувуу мэт давхин оджээ.

Орон зай гурван хэмжээстэй байхад цаг хугацаа яагаад ганцхан хэмжээстэй байдаг юм бол доо, хөөрхий ...

С Дамдиндорж

1. Дараах үгсийн утгын тайлбарыг зөв харгалзуулсан хэсгийн дугаарыг олоорой.

1. Тэнгэр	а) чихэрлэг амтат идээ

2. бал бурам	b) дотор сэтгэлдээ агуулсан занах сэтгэл
3. хавцал	c) хүний орчлонгийн дээр оршиж бүхнийг мэдэж захирах хүч түүний орших орон
4. ёс	d) гүн нь өргөнөөсөө их уулын эгц хажуутай нарийн хөндий
5. хорсол	e) нийгмийн хөгжлийн явцад янз бүрийн хэлбэрээр байх юмны зайлшгүй зүй тогтол жам

- A. 1c2e3b4a5d B. 1c2a3d4e5b C. 1c2d3b4e5a
D. 1a2b3c4d5e E. 1b2e3a4c5d

2. “Ам руугаа алгадүүлсан залуу **год үсрэн** гарч одов.” өгүүлбэрийн онцолсон үгийг солин найруулбал аль нь илүү тохиромжтой вэ?

- A. Огло харайн B. сандран C. тэвдэн D. сум шиг E. хурдан

3. *Загар зүүдэндээ хэний дээл өмссөн байсан бэ*

- A. Ноомой даруу залуугийн
B. Сугарын
C. Өөрийнхөө
D. Эхнэрийнхээ
E. Дээлгүй байсан

4 “Ямар ч байсан Загарын сэтгэлийн мұхар дахь хар хорын бодол салхинд хийсэх мэт цэлмэж, магнай тэнийтэл бах нь ханаад шувуу мэт давхин оджээ. ...” – өгүүлбэрийн дүрслэх ур маягийг тодорхойл

- A. ихэсгэл B. багасгал C. адилтгал D. зүйрлэл E. ёгтлол

5. *эхийн сэдвийг тодорхойлно уу*

- A. Анд найзуудын нандин холбоо
B. Залуу насны ааг омог
C. Цаг хугацаа бүхний захирагч
D. Ариун хайр
E. Итгэл үнэмшил ...

6. Орон зай гурван хэмжээстэй байхад цаг хугацаа яагаад ганцхан хэмжээстэй байдаг юм бол доо, хөөрхий ...гэсэн өгүүлбэрийг тодорхойл

- A.УНӨ Б. ЗНӨ В. ХУНӨ Г. ЭДӨ Д.ХоНӨ

7. *Үгсийн аймгаар зөв бүлэглэсэн хэсгийг олоорой*

- A. хурц гоёмсог хорсол халуун
B. хурц өглөө ариун халуун
C. хурц харин гэж халуун
D. хурц гоёмсог ноомой хэмжээс
E. хурц гоёмсог ариун халуун

8. “Дорнын тооллоор зул сар барагдах шөнө дундын алдад Загар сонин хачин их гэрэл гэгээ түяатай зүүдлэв....” өгүүлбэрт ямар хувиргал хийснийг олоорой.

- A. Хураах
C. Салаалах
- B. Дэлгэрүүлэх
D. Тонгоргох
- E. хувиргаагүй

9. “Сайхан зүүд хэмээн **бэлгэшээх** сацуу, “Энэ муу Сугар зүүдэнд орохоос ч бас хоцрохгүй шүү” гэж ундууцав..” тодруулсан хэсгийг утгаар нь тохируул.

- A. Сэтгэл алдахын сацуу
- B. Ихэд баярлахын хамт
- C. Сэтгэл сэргэхийн зэрэгцээ
- D. ихэд баярлахын зэрэгцээ
- E. олзуурхахын зэрэгцээ

10. “**Загар**” хэзээ зүүд зүүдэлсэн бэ

- A. навч цэцгийн дуртмал өнгө сулрахад
- B. ууган яргуй уул дамжин гүйж байхад
- C. хөв хөх тэнгэрээс цав цагаан үүл ойчих үед
- D. оодогносон тугалын салаа туруунд оготно сүүлээ тасдуулах шахахад

ХОЁРДУГААР ХЭСЭГ [30 оноо]

Санамж:

Даалгавар тус бүрийн зааврыг анхааралтай уншиж ойлгоод гүйцэтгээрэй.

Даалгавруудын хариултыг хариултын хуудсанд тэмдэглэхгүй тул шалгалтын дэвтрийн зохих зайд бичиж тэмдэглээрэй.

Даалгавар бүрийн оноо харилцан адилгүй болно.

2.1 Дараах эхийн хэсгийг уншаад зөв бичих дүрмийн алдаатай 5 үгийг олоод, засаж бичээрэй. Алдаатай 1 үгийг олвол 0,5 оноо, зөв болгон засвал 0,5 оноо. [5 оноо]

Энд таван төрлийн эмийн ургамал байна. Үнрээр нь нэрэл! гэхэд энэ л хүү яг олоод хэлчихдэг сэн. Тэр ч байтугай нүдээ боолгоод тэмтрэхэд ав адилхан чулууны дундаас гиваантайг нь олно гээч. Ховор оо, ховор бурхан минь, яах вэ дээ! Цахиуртын дэлдэн хөх маарамба жанч халхад миний нэрийг шавь минь авч үлдэнэ” хэмээн өвгөн бахархаж, утаа дортогноос будаг нь ялгарахаа байсан тоонийг ширтэж хэвтэв.

№	Ташаарсан нь	Залруулбал
1.		
2.		
3.		
4.		
5.		

2.2 Дараах эхийг уншаад кирил бичигт хөрвүүлээрэй. 0-1 алдвал 5 оноо, 2-4 алдвал 4 оноо, 5-7 алдвал 3 оноо, 8-10 алдвал 2 оноо, 11-13 алдвал 1 оноо, 14-өөс дээш алдвал 0 оноотой болно. /5 оноо/

МОНГОЛЫН ХӨРӨНГӨЛӨХ ТУЛ ХИЧЭЭНГҮЙ, ГАРГАЦТАЙ БИЧЭЭРЭЙ.
/Үгийн тоо 150-180/ [20 оноо]

2.3 Дараах өгөгдлийг үргэлжлүүлэн эх зохион бичнэ үү.
Бичихдээ эхийн сэдэв, агуулга, бүтэц, хэв шинж, найруулга зүйн шаардлагыг сайтар тооцоолж, баримт мэдээлэл, уран дүрслэлээр баяжуулахыг зөвлөж байна.

Бичгийн соёл оноонд нөлөөлөх тул хичээнгүй, гаргацтай бичээрэй.

/Үгийн тоо 150-180/ [20 оноо]

“Би ээжийнхээ нүүрэнд нь үрчлээ нэмж, гарыг нь мойног болгосон ...”

